



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2014 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 18


Өлгий

Тендерийн бичиг баримтын тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "а" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.2, 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад тендерт оролцогч аж ахуй нэгжүүдээс ТБОНӨХБАҮХАТ хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.2-т зааснаар Санхүү, төрийн сангийн хэлтсийн цахим И-баланс программаас хэвлэн гаргаж баталгаажуулсан санхүүгийн тайланг ирүүлэхийг тендерийн баримт бичигт тусгаж өгч байхыг Худалдан авах ажиллагааны алба /Х.Саулеш/, Санхүү, төрийн сангийн хэлтэс /Б.Шолпан/ нарт үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Н.САНАТБЕК